

ӨГҮҮЛЭЛ

**Монгол Улс, бүс нутгийн хамтын
ажиллагааны байгууллагууд: Боломж ба эрсдэл, аюул занал**

Авирмэдийн Даваасүрэн

Доктор (Sc.D), профессор

Шинжлэх Ухааны Академийн Олон улс судлалын хүрээлэн,

Улаанбаатар, Монгол Улс

davaasurena@mas.ac.mn

Хураангуй: Энэхүү өгүүлэлд хуучин ЗХУ-ын бүрэлдэхүүнд байсан тусгаар улсуудын хамтын нөхөрлөлийн зарим орнуудын Шанхайн хамтын ажиллагааны байгууллага, Евро-Азийн эдийн засгийн холбоог байгуулах болсон шалтгаан, тэдгээрийн зорилго, мөн чанар ба механизмуудын хэрэгжилтийг бичсэн. Энэ хоёр холбооны хүрээнд хамтын ажиллагааг хэрэгжүүлэх явцад голлох гишүүн орнуудын хооронд үүсэж буй эрх ашгийн зөрчил, энэ хоёр холбоонд Монгол улсыг гишүүнээр элсүүлэх хөрш улсын хүсэл зэргийг бичсэн байна. ЕАЭЗХ нь чөлөөт худалдааны гэрээг гуравдагч улс орнуудтай харилцах худалдааны бодлогын шинэ арга хэрэгсэл гэж үзэж дэлхийн зарим улсуудтай чөлөөт худалдааны гэрээг ДХБ-ын дүрэм, журмын хүрээнд байгуулж байна. Түүнчлэн ШХАБ болон ЕАЭЗХ-д Монгол Улс гишүүнээр элсэхгүй байх эсвэл элсэхэд бий болох боломжууд ба сул талууд, эрсдэлүүдийн талаар дүгнэлт гаргах гэж оролдсон болно. Монгол Улсад ШХАБ болон ЕАЭЗХ-д элсэхгүйгээр ажиглагчийн байр сууриа хадгалаж үлдэхийн ач холбогдолын талаар судлаач өөрийн санал, дүгнэлтийг бичсэн болно.

Түлхүүр үгс: Монгол Улс, ШХАБ, ЕАЭЗХ, ОХУ, БНХАУ, ажиглагч, гишүүнчлэл, чөлөөт худалдааны гэрээ, улс төр, дипломатын харилцаа, эдийн засгийн интеграци

Нэг. ШХАБ ба Монгол Улсын гишүүнчлэлийн асуудал

ШХАБ-ын анх байгуулагдсан гол түүний гишүүн улс орнуудад учирч зорилго бол Төв Азийн бүс нутаг дахь террорист халдлага, терроризмтай тэмцэхэд чиглэгдэж, салан тусгаарлах, хэт даврах үзэл

Received: 03 May, 2022; Accepted: 01 November, 2022

<https://orcid.org/0000-0002-1677-5789>



<https://creativecommons.org/licenses/by/4.0/>

гэсэн гурван үндсэн аюул, эрсдэлийг бууруулахад дорвитой арга хэмжээг авч байна. Эндээс үзэхэд уг байгууллагыг бүс нутгийн аюулгүй байдлын гэж ойлгогдож байгаа бөгөөд гэтэл энэхүү байгууллагыг санаачилсан зарим улс орнуудын удирдагч нар үйл ажиллагааных нь цар хүрээг өргөтгөж гишүүн орнуудын дунд худалдаа, хөрөнгө оруулалт, эдийн засгийн интеграцийг хөгжүүлж байна гэж тайлбарлахыг оролддог боловч үнэн хэрэгтээ энэ тал дээр олон улсын болон бүс нутгийн хөрөнгө оруулалтын дорвитой төслүүд хэрэгжихгүй байна гэсэн шүүмжлэлд өртөж байдаг. Өөрөөр хэлбэл ШХАБ-ын гишүүн орнууд одоог хүртэл нэгдсэн байр сууринд хүрч чадаагүй байна. Хэдийгээр уг байгууллагын гол гишүүд болох Хятад, Оросын удирдагчид 2015 оны 5-р сард Хятадын “Бүс ба зам” санаачлагыг Оросын Евроазийн эдийн засгийн холбоотой холбож тэдгээрийн төслүүдийг хооронд нь уялдуулж хамтарч хэрэгжүүлэхээр тохиролцсон боловч одоог хүртэл тодорхой ажил арга хэмжээ хэрэгжсэнгүй.

Анхнаасаа ШХАБ-ыг байгуулах БНХАУ, ОХУ-ын геополитикийн зорилго нь АНУ тэргүүтэй барууны орнуудыг нөлөөг Төв Ази руу бий болгохгүй байх замаар өөрсдийн нөлөөг бэхжүүлэхэд чиглэсэн гэж судлаачид үздэг.

ШХАБ-ыг үүсгэн байгуулсан гишүүд дотор зөрчил, маргаантай улсууд байсаар байна. Тухайлбал, ОХУ-ын дэмжлэгтэйгээр Энэтхэг Улсыг тус байгууллагын гишүүнээр элсүүлсэн нь тус байгууллага дахь БНХАУ-ын хэт ноёрхлыг хязгаарлах

зорилгоор Энэтхэг Улсыг гишүүн болохыг дэмжсээр ирсэн байдаг. ОХУ нь Төв Ази дахь “Том ах” гэсэн статусаа хадгалж бэхжүүлэхийг хүсэж байгаа бол, БНХАУ хүч нөлөөгөө тэлэхийг зорьж байна. Хятадын зүгээс ШХАБ-ын урт хугацааны хамтын ажиллагааны хүрээнд чөлөөт худалдааны бүс байгуулах, хөгжлийн банк, хөгжлийн сан байгуулах саналыг тавьж байгаа боловч ОХУ дэмжихгүй байсаар байна. Үүнтэй адил ЕАЭЗХ-г Хятадаар хүлээн зөвшөөрүүлэх ОХУ-ын оролдлогыг Хятад няцааж, хоёр талын хэлэлцээр үр дүнд хүрч чадаагүй байна. Түүнээс гадна 2002 онд ОХУ нь ШХАБ-ын бараг бүх гишүүдтэй “Хамтын аюулгүй байдлын гэрээний байгууллага” нэртэй цэргийн холбоо байгуулсан. Тэгвэл БНХАУ 2020, 2021 онд “Хятад + Дундад Азийн таван орон”-ын Гадаад хэргийн сайд нарын уулзалтыг зохион байгуулсан боловч энэ арга хэмжээндээ ОХУ-ыг оролцуулаагүй.

Монгол Улсын хувьд 2004 оноос хойш ШХАБ-ын ажиглагчийн статустай байж уг байгууллагын дээд түвшний уулзалтад оролцдог уламжлалтай¹. Гэвч хоёр хөршийн зүгээс ШХАБ-ын гишүүнээр Монгол Улсыг элсэхийг ил ба далд хэлбэрээр шахаж ирсэн байдаг. Тухайлбал, ОХУ-ын зүгээс 2014 оны 6 дугаар сард тус улсын ҮАБЗ-ийн нарийн бичгийн дарга Н.П.Патрушев Монгол Улсад айлчлахдаа Халхын голын дайны ялалтын 75 жилийн ойд ОХУ-ын Ерөнхийлөгч В.В.Путиныг оролцуулах нөхцөл болгож “ШХАБ-д элсвэл айлчлуулна” хэмээн хэлж байсан тухай баримт үлджээ².

1 Монгол Улсын Гадаад бодлогын хөх ном, 2006 (Diplomatic Bluebook), ГХЯ, МФА, 66 дахь талд

2 Монгол Улсын ҮАБЗ-ийн нарийн бичгийн даргаас ярьсан аман түүх, зохиогчийн хувийн архив

2016 онд УИХ-ын дарга М.Энхболдын ОХУ-д хийсэн айлчлалын үеэр ОХУ-ын Төрийн Думын Холбооны Зөвлөлийн дарга В.И.Матвиенко: “ШХАБ-д Монгол Улсын байр суурийг бэхжүүлэх нь зүйтэй гэж үзэж байна. Энэ байгууллагад элссэнээр Оросын, эсвэл Хятадын нөлөөнд орно гэж үздэг улстөрчид танайд бийг би мэднэ. Энэ бол огтхон ч тийм биш. Харин ч танай улсад илүү ашигтай байх болно. Газар зүйн байрлал, эдийн засгийн нөхцөл байдал гээд аль ч талаараа Монгол Улс энэ байгууллагын бүрэн эрхт гишүүн байх боломжтой”³ хэмээн хэлж байжээ.

2018 онд БНХАУ-ын дарга Ши Жиньпин: “Монгол бол ШХАБ-ын анхны ажиглагч орон. Монголын тал ШХАБ-тай хамтын ажиллагааны түвшнээ дээшлүүлэхийг Хятадын тал дэмжинэ. ШХАБ-ын хүрээн дэх зохицуулалт, хамтын ажиллагаагаа өргөтгөн, ШХАБ-ын хамтын ажиллагаанд Монголын тал гүнзгий оролцохыг сайшаана” гэжээ. 2019 онд тэрээр хэлсэн үгэндээ “Цаашид Монгол Улс ШХАБ-д нэгдэн орвол өөрийн давуу талыг улам сайн ашиглаж, бүс нутгийн хамтын ажиллагаанд гүн оролцож, бодитой үр ашиг хүртэнэ. Монгол Улс ШХАБ-д гишүүнээр элсэх шийдвэр эрт гаргах тусам бүс нутгийн хамтын ажиллагааны олон боломжийг хуваалцах болно” гэжээ.

ШХАБ-д элсэх эсэх дээр албан ёсны хариуг Монгол Улсын Ерөнхийлөгч ШХАБ-ын 2017, 2018, 2019 оны өргөтгөсөн гурван ч дээд уулзалт, 2020 оны ШХАБ-ын дээд хэмжээний

цахим уулзалт дээр маш тодорхой өгч, байр сууриа илэрхийлж ирсэн байдаг. Тухайлбал, 2019 оны дээд хэмжээний уулзалт дээр Ерөнхийлөгч Х.Баттулга “Монгол Улс ШХАБ-д шат ахиулан оролцох боломжийг нарийвчлан судалж байгаа бөгөөд зохих хэлэлцүүлгийг улс төр, нийгмийн хүрээнд явуулж байгаа талаар та бүхэнд мэдээлж байсан билээ. Монгол Улсыг ШХАБ-д элсүүлэх асуудлаар манай улсын дотоодод олон нийтийн санал бодол хуваагдмал байдалтай байна”⁴ гэж хэлж байжээ.

Тэрээр 2020 онд мөн байр сууриа⁵ тодорхой илэрхийлэхдээ: - Монгол Улс ШХАБ-ын төлөвшилтийг анхааралтай ажиглан, холбогдох судалгаануудыг хийж, эдийн засгийн болон хүмүүнлэгийн салбарын практик үйл ажиллагаанд ажиглагчийнхаа байр суурийг хадгалан, идэвхтэй оролцохыг эрмэлзэж байна. Монгол, Орос, Хятад гурван улсын “Эдийн засгийн коридор”-ын чухал бүрэлдэхүүн хэсэг болох хурдны авто зам, төмөр замын төв, зүүн болон баруун коридорын төслүүдийг урагшлуулах нь Зүүн Ази ба Төв Азийн зах зээлийг холбож ШХАБ-ын хүрээний хамтын ажиллагааг улам гүнзгийрүүлэх юм. Бидэнд ийм практик ач холбогдолтой, бодит үр дүнтэй үйл ажиллагаа чухал байгааг онцлон тэмдэглэе гэжээ.

Монгол Улс Шанхай хамтын ажиллагааны байгууллагын ажиглагчаар үлдэхийн давуу тал ба боломжууд:

- Тус байгууллагын үндсэн зорилго алан хядлага, хэт

3 Төрийн Думын болон Холбооны зөвлөлийн дарга нартай уулзлаа, parliament.mn/news/2016.12.17

4 Монгол Улсын Ерөнхийлөгч Х.Баттулга ШХАБ-ын өргөтгөсөн хуралдаанд оролцож үг хэллээ, president.mn/9379/

5 Монгол Улсын Ерөнхийлөгч Х.Баттулга ШХАБ-ын өргөтгөсөн цахим хуралдаанд оролцож үг хэллээ, president.mn/16801/

даврах, салан тусгаарлах, терроризмтой тэмцэх, бүс нутгийн улс төр, аюулгүй байдлын асуудлын хүрээнээс хальж гишүүн орнуудын дунд худалдаа, эдийн засаг, хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтын хамтын ажиллагааны эхлэлийг тавьж чадаагүй, тус байгууллагад БНХАУ болон ОХУ давамгайлж өөрсдийн байр суурийг гишүүн бусад улсуудад тулгах, тэдэнд сайхан зүйл амласан байдалтай, уг байгууллагын үйл ажиллагаа нь гишүүн орнуудын төрийн тэргүүн нарын уулзалтаас хэтрэхгүй, ирээдүй нь тодорхой бус байгаа нөхцөлд Монгол Улс ажиглагчийн статусаа хадгалаж үлдэх нь илүү дээр байх.

- Монгол Улс энэхүү байгууллагын гишүүн Төв Азийн орнуудтай (ОХУ-аас гадна) шууд хиллэдэггүй, гишүүн орнуудтай худалдаа, эдийн засаг, хөрөнгө оруулалтын хамтын ажиллагаа сайн хөгжөөгүй, газар нутгийн маргаан, зөрчил байхгүй, терроризм, салан тусгаарлах ба шашны хэт даврах үзэл, зэр зэвсгийн хууль бус худалдаа, дүрвэгсдийн асуудал хараахан байхгүй, уг байгууллагад хувь оролцоо байхгүй учир одоогийн байдлаар Монгол Улсад гишүүнээр элсэхгүйгээр ажиглагчийн статусийг одоохондоо хадгалах нь зүйтэй юм.

Сул тал ба эрсдэл:

- Тус бүс нутгийн улс төр, эдийн

засаг, нийгэм, хүмүүнлэг, геополитикийн аюулгүй байдлын тулгамдаж буй асуудлуудыг шийдэхэд Монгол Улс биечлэн оролцох боломж хумигдана.

- ШХАБ-ын гишүүн хөгжиж байгаа орнуудын зүгээс бодит байдал дээр Монгол Улсын хөгжил, аюулгүй байдлын талаар дэмжлэг авах боломж хязгаарлагдмал учир манай улс ганцаардах, бидний дуу хоолой дэлхий нийтэд хүрэхэд хүндрэлтэй байж болох юм.
- ШХАБ-ын гишүүн Төв Азийн орнуудтай нүүдэлчдийн соёл, зан заншил хэлний язгуурын ижил төстэй байдал устаж арилах магадлалтай.
- Төв Азийн орнуудын ард түмэн өөрсдийгөө Чингис хааны үр сад гэж үздэг, Чингис хаан, Бат хааныг өөрсдийнхөө хаан гэж үздэг, Монголчуудтай мах цусны барилдлагатай гэж үздэг, монголчуудыг хүндэлж харьцдаг зэрэг нийгэм, хүмүүнлэгийн уламжлалт сайхан харилцаа бүдгэрэх, алсрах магадлалтай.

Аюул занал:

- Хоёр хөршүүд үгсэн тохиролцож Монгол Улсын хил хязгаар, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдал, тусгаар тогтнол, үндэсний аюулгүй байдал, хөгжил, цэцэглэлт, эдийн засаг, хөрөнгө оруулалтын салбарт хамтын ажиллагааг хөгжүүлэх гадаад гуравдагч орны аливаа санал, санаачилгыг боогдуулах, бидний хийхээр төлөвлөж

байгаа төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэхгүй, хаах хориглох, дарамтлах, бойкотлох замаар хөгжүүлэхгүй байх магадлалтай.

Монгол Улс ШХАБ-ын гишүүнээр элсэхэд бий болох давуу тал ба боломжууд:

- Уг байгууллагын хүрээнд бүс нутгийн тулгамдаж буй хурц асуудлуудыг шийдвэрлэхэд Монгол Улсын оролцоо, дуу хоолой нэмэгдэж, гадаад нэр хүнд дээшлэх магадлалтай.
- Төв Азийн орнуудын ард түмэнтэй соёл, нийгэм, хүмүүнлэгийн харилцаа гүнзгийрнэ.
- ОХУ болон БНХАУ-ын тээвэр, логистикийн дотоодын сүлжээг ашиглаж тус байгууллагын гишүүн болон ажиглагч гишүүн орнуудтай улс төр, дипломатын харилцаа болон худалдаа, эдийн засаг, хөрөнгө оруулалтын хамтын ажиллагааны цар хүрээг өргөжүүлэх боломжтой.
- Уг байгууллагын хүрээнд одоогоор яригдаж байгаа олон улсын болон бүс нутгийн хөрөнгө оруулалт, дэд бүтцийн бүтээн байгуулалтын төсөл, хөтөлбөрүүдэд Монгол Улс оролцох эрх нээгдэх магадлалтай.
- ОХУ болон БНХАУ-ын дунд байрлах Монгол Улсын газар зүй, хил хязгаарын түгжигдмэл байдалд эерэг өөрчлөлт гарах магадлалтай.

Сул тал ба эрсдэл:

- ШХАБ-д гишүүнээр элсэх нь Монгол Улс гуравдагч хөршийн бодлогоо тууштай хэрэгжүүлэхэд хүндрэлтэй болно.
- Уг байгууллагад ОХУ, БНХАУ давамгайлсан, ялангуяа Хятад аж үйлдвэржсэн илүү өндөр хөгжилтэй, техник, технологи, мөнгө санхүүгийн хувьд чадамжтай учир Монгол Улсыг улс төр, эдийн засаг, нийгмийн хувьд уусгах, өөртөө нэгтгэх үйл явц түргэсэх эрсдэлтэй болно.
- ОХУ, БНХАУ-аас гадна ШХАБ-ын гишүүн бусад орнууд нь газар зүйн хувьд Монгол Улсаас алс хол учир худалдаа, эдийн засаг, хөрөнгө оруулалтын үр ашгаас илүү террорист үйл ажиллагаа, салан тусгаарлах үзэл, дүрвэгсэд, хар тамхины хууль бус наймаа Монгол Улсад халдварлах эрсдэлтэй юм.

Дүгнэж хэлэхэд хэрэв Монгол Улс олон тулгуурт гадаад улс төрийн бодлого явуулж, өрнө, дорнын өндөр хөгжилтэй орнуудтай найрсаг харилцаатай байя, тэдний эрх ашгийг Монгол Улсад байлгая гэвэл ШХАБ-ын ажиглагчийн статус дээрээ хатуу зогсож, ажиглагчийн эрхээ эдэлнэ гэдгээ уг байгууллагын гишүүн орнуудад ойлгуулсан нь зүйтэй байх. ОХУ, БНХАУ-тай тогтоосон найрсаг харилцаа, хамтын ажиллагааг гуравдагч хөрш орнуудтай тогтоосон харилцаатай уялдуулан тэнцвэржүүлэх бодлогоо одоохондоо үргэлжлүүлэх нь зүйтэй гэж үзэж байна.

Хоёр. ЕАЭЗХ ба Монгол Улсын гишүүнчлэлийн асуудал

Анх 2012 онд ОХУ, Беларусь, Казахстан гаалийн холбоог байгуулж гишүүн орнуудын эдийн засгийг тогтвортой бөгөөд үр дүнтэй хөгжүүлэх, хүн амын амьжиргааны түвшнийг дээшлүүлэх нөхцөлийг бүрдүүлэх эдийн засгийн нэгдсэн орон зай байгуулах зорилгоор байгуулсан бол 2014 оны 5 дугаар сарын 29-ий өдөр эдгээр 3 орнууд ЕвроАзийн эдийн засгийн холбоог байгуулах гэрээнд гарын үсэг зурж 2015 оны 1 дүгээр сарын 01-ий өдрөөс эхлэн албан ёсоор хэрэгжиж эхэлсэн. Энэхүү гэрээг 2015 оны 1 дүгээр сараас эхлэн Армян, Кыргызстан албан ёсоор хүлээн зөвшөөрч уг байгууллагын гишүүнээр элссэн.

Одоогийн байдлаар ЕвроАзийн эдийн засгийн холбооны ажиглагч гишүүнээр 2018 оноос Молдова, 2020 оноос Узбекистан, Куба зэрэг улсууд элссэн. Энэ хүрээнд гишүүн улс орнуудын засгийн газар хоорондын хамтын ажиллагааг хангах эрх үүрэгтэй ЕвроАзийн комиссыг байгуулж, аливаа маргааныг шийдвэрлэх ЕвроАзийн шүүхийг байгуулан ажиллуулж байна.

Энэхүү холбооны стратегийн зорилго нь ЗХУ-ийн бүрэлдэхүүнд байсан тусгаар тогтносон улсуудын эдийн засгийн интеграцчлалыг эрчимжүүлэхэд чиглэгдэж байна.

ЕвроАзийн эдийн засгийн холбооны гуравдагч улс орнуудтай харилцах худалдааны бодлогын шинэ арга хэрэгсэл болгож чөлөөт

худалдааны бүсийг (Чөлөөт худалдааны хэлэлцээр, гэрээ ч гэж нэрлэж байна) 2011 оны 11-р сарын 18-ны өдөр Евроазийн эдийн засгийн комиссын шийдвэрээр байгуулсан. Энэхүү чөлөөт худалдааны бүс нь ДХБ-ын дүрэм, журмын хүрээнд гэрээнд оролцогч талуудын үйлдвэрлэлийн болон санхүүгийн тогтвортой байдлыг хангах, эдийн засгийн хөгжлийг хурдасгах зорилгоор тэдгээрийн хооронд эдийн засгийн болон чөлөөт худалдааг өргөжүүлэх хөгжүүлэх, гэрээг хамтран хэрэгжүүлэх үр дүнтэй журмыг бий болгоход чиглэгдэж байна. ЕвроАзийн эдийн засгийн холбоотой чөлөөт худалдааны бүс байгуулах гэрээнд 2016 онд Вьетнам, 2017 онд Иран, 2019 онд Серби улсууд нэгдэн орсон. 2019 оны 1 дүгээр сарын 1-ий өдөр Серби улс ЕвроАзийн эдийн засгийн комиссын хоорондын худалдааны бараа, бүтээгдэхүүн, түүхий эдэд ногдуулах гаалийн импортын татварыг барааг тодорхойлох, кодлох уялдуулах системийн (БТКУС) дагуу “0” байхаар тохиролцож чадсан⁶. Уг холбооны гишүүн Армен, Беларусь, Казахстан, Кыргызстан, ОХУ-тай 2017 оноос эхлэн Сингапур, Египет, Энэтхэг зэрэг улсууд чөлөөт худалдааны бүс байгуулах хэлэлцээрийг эхлүүлсэн. 2019 оны 1 дүгээр сарын 01-ий өдөр Сингапур ЕАЭЗХ-той чөлөөт худалдааны гэрээ байгуулж гаалийн татварыг “0” болгосон 10 жилийн хугацаанд гадаад худалдааг үе

6 Соглашение о зоне свободной торговли между Евразийским экономическим союзом и его государствами-членами, с одной стороны, и Республикой Сербия, с другой стороны, http://www.eurasiancommission.org/ru/act/trade/dotp/sogl_torg/Documents/.pdf

шаттайгаар чөлөөлөхөөр тохиролцсон байна⁷. Түүнчлэн ЕвроАзийн эдийн засгийн холбооны зүгээс Чөлөөт худалдааны гэрээ байгуулах саналыг зөвхөн Монгол Улс, Хятад, БНСУ, Европын холбоо, АСЕАН зэрэг улсуудад тавиад байна.

Монгол Улсын Засгийн газар, ЕвроАзийн эдийн засгийн комиссын хооронд 2015 оны 6 дугаар сард байгуулсан “хамтын ажиллагааны санамж” бичгийн хүрээнд хөдөө аж ахуй, аж үйлдвэрийн цогцолбор, өрсөлдөөний бодлого, техникийн зохицуулалт, мал эмнэлэг, эрүүл ахуйн болон хорио цээрийн ургамал эрүүл ахуйн арга хэмжээг ашиглах чиглэлээр ЕАЭЗХ-ны орнууд болон Монгол Улс харилцан тохиролцсоны үндсэн дээр худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааг хөгжүүлж байна.

Дараа нь 2017 оны 6 дугаар сард Санкт-Петербургийн олон улсын эдийн засгийн форумын үеэр Монгол Улсын Ерөнхий сайд ЕАЭЗХ-тай Чөлөөт худалдааны хэлэлцээр байгуулахад бэлэн байгаагаа мэдэгдэж, үүний тулд ЕАЭЗХ, Монгол Улсын хооронд худалдааны яриа хэлэлцээрийг хөгжүүлэх зорилгоор хамтарсан судалгааны хэсэг байгуулан ажиллаж байна.

ЕАЭЗХ-той Чөлөөт худалдааны хэлэлцээр байгуулах асуудлаар Монгол Улсад санал тавьж хэд хэдэн удаа холбооны удирдлага, Нарийн бичгийн дарга нарын газрын түвшинд зөвлөлдөж байгаа боловч уг холбооны зүгээс хэлэлцээр эхлүүлэх шийдвэрийг одоогоор гараагүй байна.

2014 онд Гадаад хэргийн яамны захиалгаар бидний хэсэг

эрдэмтдийн хийсэн “Монгол Улс, ОХУ хоорондын чөлөөт худалдааны хэлэлцээр”-ийн төслийн үндэслэл боловсруулах судалгааны ажлын үр дүн” судалгааны ажлын хүрээнд ОХУ-тай хийж байгаа манай улсын гадаад худалдааны экспорт, импортын харьцангуй давуу талын индексийг тооцож үзэхэд чөлөөт худалдааны хэлэлцээр байгуулах нь Монгол Улсад ашиггүй гэсэн дүгнэлт гарсан. Энэ нь Монгол Улс нь үйлдвэрлэгч буюу экспортлогч биш, хэрэглэгч буюу импортлогч улс учир манай улсын экспортын бараа, бүтээгдэхүүний өрсөлдөх чадвар гадаадын зах зээл дээр сул, дотоодын хэрэглээний дийлэнх хэсгийг импортын бэлэн бараа, бүтээгдэхүүнээр хангадаг, экспортын бүтцэд уул уурхайн болон мал аж ахуйн түүхий эд зонхилж байгаагаас шалтгаалж байна.

Олон улсын практикаас харахад нэг талаас дотоодод үйлдвэрлэсэн бэлэн бараа, бүтээгдэхүүний экспортын тоо хэмжээг нэмэгдүүлэх, нөгөө талаас дотоодын үйлдвэрлэлд хэрэгцээтэй түүхий эдийг л зөвхөн импортлох зорилгоор чөлөөт худалдааны хэлэлцээр байгуулж байна. Тухайлбал, АНУ, ЕХ, ОХУ зэрэг томоохон импортлогч улсуудын дотоод зах зээлийн их хэмжээний хэрэгцээг урт удаан хугацаанд найдвартай хангахуйц, уг зах зээлийн чанар, стандартын шаардлагад нийцсэн иж бүрэн сертификатжсан их хэмжээний бараа бүтээгдэхүүн үйлдвэрлэх өргөтгөсөн нөхөн үйлдвэрлэлийг зохион байгуулах хүчин чадалтай, эдгээр бараа, бүтээгдэхүүнээ тээвэрлэж уг зах зээлд хүргэж өгөхдөө олон улсын болон

7 Страны ЕАЭС и Сингапур подписали соглашение о зоне свободной торговли
<https://www.zakon.kz/4988331-strany-caes-i-singapur-podpisali.html>

бүс нутгийн тээвэр, логистикийн сүлжээг ашиглаж чаддаг БНХАУ, БНСУ, Япон, Австрали зэрэг томоохон экспортлогч улсууд чөлөөт худалдааны хэлэлцээрийг ашгийг бүрэн хүртэж чадаж байна.

Одоогоор Монгол Улс ямар нэгэн холбоо, эвсэлд нэгдээгүй цөөхөн улс орнуудын нэг бөгөөд хэрэв тус улс уг холбоонд гишүүнээр элсэхэд энэ статус нь автоматаар хүчингүй болох олон улсын эрх зүйн үндэс бий болох эрсдэлтэй юм. Энэ нь манай улсын гадаад бодлогын үзэл баримтлалын 14.2.-д “АНУ, Япон, Европын холбоо, Энэтхэг, БНСУ, Турк зэрэг өрнө, дорнын улс, холбоотой “гуравдагч хөрш”-ийн бодлогын хүрээнд түншлэлийн найрсаг харилцаа, хамтын ажиллагааг өргөжүүлэн хөгжүүлэх” заалттай зөрчилдөхөд хүрч магадгүй юм.

Монгол Улс ЕАЭЗХ-д гишүүнээр элсэхгүй байхын давуу тал ба боломжууд:

- Монгол Улс аль нэг холбоо эвсэлд нэгдэхгүйгээр өөрийнхөө гуравдагч хөршийн бодлогоо тууштай хэрэгжүүлж дэлхийн улс үндэстнүүдтэй бүх талын тэгш бөгөөд найрсаг харилцаа, хамтын ажиллагаагаа үргэлжлүүлэх боломжийг хэвээр хадгалах.
- Монгол Улсын цэрэг, дайчид НҮБ-ын энхийг сахиулах үйл ажиллагаанд оролцох ажлаа үргэлжлэх боломжоо хадгалах.
- Монгол Улс нь ОХУ, БНХАУ-ын харилцааг тэнцвэржүүлэх замаар бүс нутгийн аюулгүй байдлыг хангах давуу талаа хадгалах,

- Монгол Улсын ардчилал, зах зээлийн эдийн засгийн замналаар хөгжих боломж нээлттэй хэвээр үлдэнэ.

Сул тал ба эрсдэл:

- Монгол Улс маш цөөхөн нэр төрлийн бараа, бүтээгдэхүүний экспорт нь ЕАЭЗХ-ы гишүүн ОХУ, Казахстан гэсэн хоёрхон улсаар хязгаарлагдаж, ОХУ-тай худалдаа, эдийн засаг, хөрөнгө оруулалтын хамтын ажиллагаанд ахиц дэвшил одоохондоо гарахгүй байна.
- Монгол Улс нь газрын тосны болсон хүнсний бараа, бүтээгдэхүүний ОХУ-аас импортын хараат байдал, уул уурхайн зарим түүхий эдийн экспорт дээр ОХУ-тай өрсөлдөгч нь байсаар байх болно.
- ОХУ-ын БНХАУ-тай харилцах харилцаа, шийдэхэд төвөгтэй хурц асуудлыг шийдэхэд Монгол Улсыг ашиглах үйл явц үргэлжлэх магадлалтай.
- НҮБ-ын энхийг сахиулах үйл ажиллагаанд Монгол Улсын цэрэг, дайчид оролцох ажил зогсох эрсдэлтэй.

Монгол Улс ЕАЭЗХ-д гишүүнээр элсэхийн давуу тал ба боломж:

- ЕАЭЗХ-д улс орнуудын зах зээлд экспортлох манай улсын барааны зах зээлийн хил хязгаар, цар хүрээ тэлж, экспортын барааны нэр төрөл олширч, энэхүү зах зээл дээрх эрэлтийг дагаад манай улсад боловсруулах үйлдвэрийн хүчин чадал

нэмэгдэж, өргөн хэмжээний нөхөн үйлдвэрлэлийг зохион байгуулах боломж бүрдэнэ.

- ЕАЭЗХ-тай байгуулах чөлөөт худалдааны гэрээний дагуу манай улсын бараанд ногдуулж байгаа гаалийн тарифын болон тарифын бус хориг саад байхгүй болж манай улсын экспортын барааны үнэ энэ холбооны зах зээл дээр буурч өрсөлдөх чадвар дээшилнэ.
- ОХУ, Монгол Улсын хороонд худалдаа, эдийн засаг, хөрөнгө оруулалтын хамтын ажиллагаа, улс төрийн харилцаа сайжирна.
- Монгол Улсын эрчим хүчний дотоод хангамж сайжирч аж үйлдвэржих боломж нээгдэнэ.

Сул тал ба эрсдэл:

- Монгол Улсын экспортын бараа, бүтээгдэхүүн энэхүү зах зээлд нэвтрэхээс өмнө энэ байгууллагын гишүүн орнуудын барааны экспорт манай орны боловсруулах үйлдвэрүүдийн барааг манай зах зээлээс шахах эрсдэл үүснэ.
- Монгол Улс нь Үндэсний Аюулгүй байдлын үзэл баримтлал, Гадаад бодлогын үзэл баримтлалд заасан тулгуур зорилтуудаа хэрэгжүүлэх боломж хязгаарлагдаж, ОХУ-аас улс төрийн болон эдийн засаг, нийгэм, хүмүүнлэгийн хараат байдал нэмэгдэнэ.

Тав. Дүгнэлт

ШХАБ нь террорист халдлага, салан тусгаарлах, хэт даврах үзэл, хар тамхины хууль бус наймаатай тэмцэх, бүс нутгийн аюулгүй байдлыг хангах зорилготой байгуулагдсан боловч бодит байдал дээр эдийн засаг, хөрөнгө оруулалтын хамтын ажиллагаа ярьсан, хэрэгжээд байгаа бодитой хөрөнгө төсөл, хөтөлбөр байхгүй, зөвхөн гишүүн улсуудын төрийн тэргүүн нарын уулзалтаар хязгаарлагдсан, өөр төрлийн механизм байхгүй байхад ЕАЭЗХ нь эдийн засгийн хамтын ажиллагааг бэхжүүлэх зорилготой байгуулагдсан боловч бодит байдал дээр энэхүү холбооны үйл ажиллагаа зөвхөн худалдаагаар хязгаарлагдаж үндсэндээ улс төрийн үйл ажиллагаа явуулж байна. Энэхүү хоёр байгууллагын гол зорилго, үйл ажиллагаа нь хуучин ЗХУ-ын бүрэлдэхүүнд байсан Төв Азийн улс орнуудын орон зайд АНУ-ын

байр суурийг бий болгохгүй, шахах зорилготой геополитикийн улс төрийн үйл ажиллагаа гэж үзэхээр байна. Тэгсэн мөртөө энэ хоёр байгууллагыг толгойлж байгаа ОХУ, БНХАУ өнгөцхөн харахад нэгдмэл мэт боловч өөр хоорондоо далдуур зөрчилтэй байна. Энэ хоёр улсууд Монгол Улсыг ЕАЭЗХ, ШХАБ-д хоёуланд нь элсэхийг ятгаж байна.

Иймд ЕАЭЗХ болон ШХАБ-д элсэхээс илүү олон туйлт дэлхийн шинэ дэг журмын төлөвшилд анхаарлаа хандуулах нь чухал юм. Энэ нөхцөлд ОХУ болон БНХАУ-тай тэнцвэртэй харьцах бодлого, гурвалсан хөршийн бодлого, «гуравдагч хөрш»-ийн бодлогыг хооронд нь ухаалгаар тэнцвэржүүлэх, АНУ, ЕХ, Япон, ОХУ, БНХАУ, БНС, Энэтхэг зэрэг улсуудын хүчний харьцаа, нөлөө, эрх ашгийн тэнцвэрийг зохист түвшинд барьж харьцах шаардлага шинээр тавигдаж байна.

Монгол Улс ямар нэгэн олон улсын эвсэл, холбоонд, ялангуяа ЕАЭЗХ, ШХАБ-д жинхэнэ гишүүнээр элсэх нь бидний язгуур ашиг сонирхолд нийцэж байгаа эсэхийг сайтар судалж шинжлэх, шинжлэх ухааны үндэслэлтэй дүгнэлт гаргах, эдгээр

холбоодтой хэрхэн, яаж цаашдаа хамтран ажиллах замын зургийг тодорхойлох, үүнээс манай улсад бий болох эрх ашиг, боломж, эрсдэл, аюул, заналыг тодорхойлох зорилготой нэмэлт судалгааг эрдэмтдээр хийлгэх шаардлагатай байна.

Ном зүй:

1. Монгол Улсын Гадаад бодлогын хөх ном, 2006 (Diplomatic Bluebook), ГХЯ, МФА, 66 дахь талд
2. Монгол Улсын Ерөнхийлөгч Х.Баттулга ШХАБ-ын өргөтгөсөн хуралдаанд оролцож үг хэллээ, president.mn/9379/
3. Монгол Улсын Ерөнхийлөгч Х.Баттулга ШХАБ-ын өргөтгөсөн цахим хуралдаанд оролцож үг хэллээ, president.mn/16801/
4. «Шанхай»-г улс төр-стратегийн эвсэл байлгахын төлөөх Орос, “Засгийн газрын мэдээ”, 2017.06.23 № 120 (666);
5. “Монгол Улсын гадаад бодлогын зангилаа асуудлууд” / Хамтын бүтээл, төслийн удирдагч А.Даваасүрэн, Хөгжлийн бодлогын судалгааны хүрээлэн, “Бэмби сан” хэвлэх үйлдвэр, Улаанбаатар, 2020,14,75 х.х. Монгол Улсын ҮАБЗ-ийн нарийн бичгийн даргаас ярьсан аман түүх, зохиогчийн хувийн архив
6. Төрийн Думын болон Холбооны зөвлөлийн дарга нартай уулзлаа, parliament.mn/news/2016.12.17
7. Б.Хакимов: ШХАБ Монголыг дуртайяа гишүүнээр элсүүлнэ, Монцамэ агентлаг, <https://sonin.mn/news/politics-economy/82725>
8. VOA “UN Security Council Reform May Shadow Annan’s Legacy” (Nov 1, 2006) <https://web.archive.org/web/20061102142909/http://voanews.com/english/2006-11-01-voa46.cfm>
9. CNN Brazil “Secretário-geral da ONU diz que Covid-19 deixou o mundo de joelhos” <https://www.cnnbrasil.com.br/internacional/secretario-geral-da-onu-diz-que-a-covid-19-deixou-o-mundo-de-joelhos/>
10. Василий Кашин “Выйти из тени” Россия в глобальной политике №2 2012 Марта/Апрель <https://globalaffairs.ru/articles/vyjti-iz-teni/>
11. ‘With Rare Double UN Veto on Syria, Russia and China Try to Shield Friend’ <http://www.heraldtribune.com/article/20111005/ZNYT03/110053039?p=4&tc=pg>
12. China Power, CSIS “Is China Contributing to the United Nations’ Mission?” <https://chinapower.csis.org/china-un-mission/>
13. VOA “China Signs Plan to Fulfill \$1B UN Pledge” (May 06, 2016) <https://www.voanews.com/east-asia/china-signs-plan-fulfill-1b-un-pledge>
14. The United Nations “UN Peace and Development Trust Fund supports multilateralism” <https://www.un.org/en/delegate/un-peace-and-development-trust-fund-supports-multilateralism>

15. Соглашение о зоне свободной торговли между Евразийским экономическим союзом и его государствами-членами, с одной стороны, и Республикой Сербия, с другой стороны, http://www.eurasiancommission.org/ru/act/trade/dotp/sogl_torg/Documents/.pdf
16. Страны ЕАЭС и Сингапур подписали соглашение о зоне свободной торговли
17. <https://www.zakon.kz/4988331-strany-eaes-i-singapur-podpisali.html>
18. Налог на добавленную стоимость (НДС), Федеральная налоговая служба, <https://www.nalog.gov.ru/rn77/TAXATION/TAXES/NDS/>
19. Изменение ставок таможенных сборов с 1 августа 2020г. https://titan74.ru/useful_information/reference_fea/change_of_rates_of_customs_duties_from_august_1_2020.

Mongolia and regional cooperation organizations: Opportunities and risks

Davaasuren Avirmed

Sc.D

*Institute of International Studies, Mongolian Academy of Sciences,
Ulaanbaatar, Mongolia
davaasurena@mas.ac.mn*

Abstract: *This article describes the reasons for the establishment of the Shanghai Cooperation Organization and the Eurasian Economic Union in some countries of the Commonwealth of Independent States that were part of the former Soviet Union, their goals, nature and implementation of mechanisms. There are written conflicts of interest arising between the main member countries during the implementation of cooperation within the framework of these two associations, as well as the desire of neighboring countries to admit Mongolia to these two associations. The Eurasian Economic Union considers free trade agreements as a new trade policy tool for relations with third countries and is establishing free trade agreements with some countries in the framework of WTO rules and regulations.*

In addition, an attempt has been made to conclude on the opportunities, weaknesses, and risks of Mongolia not joining the Shanghai Cooperation Organization and the Eurasian Economic Union. The researcher wrote his opinions and conclusions about the importance of maintaining the position of an observer in Mongolia without joining these two regional organizations.

Keywords: *Mongolia, Shanghai Cooperation Organization, Eurasian Economic Union, Russia, China, observer, membership, free trade agreement, politics, diplomatic relations, economic integration*

<i>The day of submission:</i>	<i>2022.05.03</i>
<i>Completion of review:</i>	<i>2022.06.06</i>
<i>Final decision for acceptance:</i>	<i>2022.11.01</i>